



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн  
2019 оны санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/2/СТА-ОНӨААН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
(Дорноговь аймаг Сайншанд сум)  
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа  
Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn  
Аудитын менежерийн үүргийг  
түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг  
Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg@audit.gov.mn  
Аудитор: Б.Отгон-Өлзий  
Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
Менежментийн захидал.....	11
Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 9 дүгээр хавсралтыг зөрчсөн байна. ....	12
3.2.2 Эрсдэл: .....	12
Бараа материалын норм нормативыг мөрдөөгүй байх.....	12
3.2.3 Өгсөн зөвлөмж: .....	12
Дугуйны гүйлтийн нормыг, аккумуляторын ашиглалтын хугацааг баримтлах, засварыг ..	12
техникийн болон ӨХБКомиссын шийдвэрээр хийх .....	12
3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	12
Зөвлөмжтэй танилцсан хэрэгжүүлж ажиллана.....	12
Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13

## Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ЗАМЫН-ҮҮД НААҮ ОНӨХХК-НИЙ  
ЗАХИРАЛ Ө.НАРАНТУЯА ТАНАА

2020.02.28 № 1-6/170  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨХХК-ний 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨХХК-ний 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨХХК-ний 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ө.Нарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС/УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 сарын 11-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдөр- эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ийн аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК 2019 оны санхүүгийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн эрхэм зорилго нь Замын-Үүд сумыг цэвэр, цэмцгэр байлгаж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ариутгал цэвэрлэгээний үйл ажиллагаа
- Уур үйлдвэрлэл халуун ус хангамж
- Ус хуримтлуулан ариутган түгээх үйл ажиллагаа

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн санхүүгийн тайлант бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Leader" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 44 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 921,462.3 мянган төгрөгөөс тооцон 18,429.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,764.2 мянган

төгрөгөөр буюу 06 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	146,498.4	1,518.1	-144,980.3
Авлага	974.5	974.5	
Урьдчилгаа			
Бараа материал	7,525.0	19,134.4	11,609.4
Үндсэн хөрөнгө	4,502,928.3	4,910,172.7	407,244.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,079,029.2</b>	<b>3,098,793.4</b>	<b>19,764.2</b>
Өр төлбөр	43,051.3	60,578.5	17,527.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,035,977.9	3,038,214.9	2,237.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,079,029.2</b>	<b>3,098,793.4</b>	<b>19,764.2</b>

Авлага дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй байна. Энэ авлага нь барагдах боломжтой авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 11,609.4 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын үлдэгдэл 1,183.3 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материалын үлдэгдэл 1,567.5 мянган төгрөгөөр, аж ахуйн үлдэгдэл 1,015.3 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгслийн үлдэгдэл 1,287.2 мянган төгрөгөөр, барилгын материалын үлдэгдэл 476.1 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материалын үлдэгдэл 6,080.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 407,244.4 мянган төгрөгөөр өссөн нь барилга, байгууламж 265,611.5 мянган төгрөгөөр, тээврийн хэрэгслийн үлдэгдэл 150,534.1 мянган төгрөгөөр өсч, тоног төхөөрөмжийн үлдэгдэл 4,097.2 мянган төгрөгөөр, тавилга, эд хогшлын үлдэгдэл 2,948.9 мянган төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2,505.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалт, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан мянган төгрөгийн 394,864.5 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд 24,139.0 мянган төгрөгийн хөрөнгөөр буурсан байна.

Өр төлбөр дансны 17,527.2 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн өглөг 1,553.1 мянган төгрөгөөр, татварын өглөг 3,274.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 15,955.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,038,214.9 мянган төгрөг болж 2,237.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд өмчид гарсан өөрчлөлт буюу дахин үнэлгээний бууралтаас шалтгаалжээ.

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн тайлант онд 637,202.9 мянган төгрөгийн орлого оруулсан байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого		635,375.6		
Хүүгийн орлого		678.7		
Үйл ажиллагааны бус орлого		1,148.6		
<b>Нийт дүн</b>		<b>637,202.9</b>		

Тайлант онд тухайн байгууллага хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 2,637.3 мянган төгрөгийн өртөг, 915,185.0 мянган төгрөгийн ерөнхий ба удирдлагын, 201.9 мянган төгрөгийн санхүүгийн зардал, 6,075.3 мянган төгрөгийн бусад зардал гаргаж 284,259.4 мянган төгрөгийг алдагдалтай ажилласан байна. Алдагдал өмнөх оноос 137,305,2 мянган төгрөгөөр өссөн байна.

Ерөнхий ба удирдлагын зардлын судалгаа

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414,103.3	438,676.6	24,573.3	105.9
НДШ-ийн зардал	47,323.8	54,521.1	7,197.3	115.2
Албан татвар төлбөр хураамж	3,201.8		-3,201.8	0.0
Даатгалын зардал		9,179.7	9,179.7	
Ашиглалтын зардал	16,566.9	22,259.7	5,692.8	134.4
Бичиг хэрэг	1,313.9	1,837.5	523.6	139.9
шатахуун	17,929.1	21,139.9	3,210.8	117.9
тээврийн	605.2	951.4	346.2	157.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,555.0	1,718.9	-1,836.1	48.4
Сургалтын зардал	986.0		-986.0	0.0
засварын зардал	44,103.1	18,875.7	-	42.8
Хөдөлмөр хамгаалал	4,327.4	4,892.7	565.3	113.1
Урсгал засвар	48,499.9	75,507.2	27,007.3	155.7
Дотоод албан томилолт	1,245.8	510.8	-735.0	41.0
элэгдэл хоргдлын зардал	246,642.6	253,884.4	7,241.8	102.9
Түрээсийн зардал	1,260.0		-1,260.0	0.0
Цэвэрлэгээ үйлчилгээний	3,161.9	7,668.7	4,506.8	242.5
Хүлээн авалтын зардал	968.9	1,800.0	831.1	185.8
Зар сурталчилгаа	857.0	940.7	83.7	109.8
Бусад	8,811.5	820.6	-7,990.9	9.3
Аж ахуйн дотоод хэрэгцээний зардал	26,926.3			
<b>Нийт зардлын дүн</b>	<b>892,389.4</b>	<b>915,185.6</b>	<b>22,796.2</b>	<b>102.6</b>

Ерөнхий ба удирдлагын зардал өмнөх оноос 2.6 хувь буюу 796.2 мянган төгрөгөөр өссөн нь валютын ханшийн өсөлттэй холбоотой байна.

### **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 48,870.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 48,870.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 48,870.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар хөрөнгийн дахин үнэлгээний 277,420.4 мянган төгрөгийн өөрчлөлтийг дахин нарийвчлан хянах шаардлагатай.

### **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж өгсөн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## **Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Актлагдсан 24,139.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөнд устгал хийлгүй данс бүртгэлээс хассан байна.
2. Авто машины сэлбэгийн ашиглалтын нормативыг мөрдөөгүй 24,731.5 мянган төгрөгийн сэлбэг зарцуулсан.

### **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1. Илрүүлэлт:**

Актлагдсан 24,139.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөнд устгал хийлгүй данс бүртгэлээс хассан байна.

Энэ нь үнэн зөв байх эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 13.3.3 “Засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж, устгах” заалтыг зөрчсөн байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Актлагдсан үндсэн хөрөнгө ашиглагдах.

##### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

Акталсан хөрөнгийг устгал хийж данс бүртгэлээс хасах.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжтэй танилцсан, хэрэгжүүлж ажиллана.**

### **3.2 Зардлын данстай холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Авто машины сэлбэгийн ашиглалтын нормативыг мөрдөөгүй 24,731.5 мянган төгрөгийн сэлбэг зарцуулсан.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 9 дүгээр хавсралтыг зөрчсөн байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

Бараа материалын норм нормативыг мөрдөөгүй байх.

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Дугуйны гүйлтийн нормыг, аккумуляторын ашиглалтын хугацааг баримтлах, засварыг техникийн болон ӨХБКомиссын шийдвэрээр хийх

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвлөмжтэй танилцсан хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>154,997,918.27</u></b>	<b><u>21,626,947.76</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	146,498,443.97	1,518,071.76
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	146,498,443.97	1,518,071.76
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	146,498,443.97	1,518,071.76
31213	Арилжааны банк дахь харилцах	146,498,443.97	1,518,071.76
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	974,464.00	974,464.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	974,464.00	974,464.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	7,525,010.30	19,134,412.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	00.00	1,183,315.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	1,183,315.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7,525,010.30	17,951,097.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	1,567,500.00
35420	Аж ахуйн материал	00.00	1,015,280.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,287,225.00
35450	Барилгын засварын материал	00.00	476,130.00
35460	Хүнсний материал	00.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	7,525,010.30	13,604,962.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,924,031,310.00</u></b>	<b><u>3,077,166,426.00</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,924,031,310.00	3,077,166,426.00
391	Газар	00.00	00.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,823,706,310.00	2,977,066,426.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,383,924,826.00	3,649,536,303.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		1,170,997,792.00	1,318,437,326.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	769,007,138.00	920,191,248.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-336,374,875.00	-419,870,204.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	207,878,197.00	203,780,978.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-76,083,632.00	-93,494,791.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,248,856.00	8,299,966.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,784,098.00	-5,745,208.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	130,869,234.00	128,364,234.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-88,981,544.00	-95,558,774.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	100,325,000.00	100,100,000.00

39301	Програм хангамж	900,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-675,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	99,875,000.00	99,875,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,079,029,228.27</u></b>	<b><u>3,098,793,373.76</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>43,051,330.46</u></b>	<b><u>60,578,481.95</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	43,051,330.46	60,578,481.95
<b>412</b>	<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	2,700,885.96	00.00
<b>4121</b>	<b>Төгрөг</b>	2,700,885.96	00.00
41216	Арилжааны банк	2,700,885.96	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	40,350,444.50	60,578,481.95
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	40,350,444.50	60,578,481.95
41361	Байгууллагад төлөх өглөг	3,015,360.00	4,013,451.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	37,335,084.50	40,609,311.00
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	00.00	15,955,719.95
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,035,977,897.81</u></b>	<b><u>3,038,214,891.81</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,035,977,897.81	3,038,214,891.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,317,397,859.00	4,603,894,247.92
51101	Өмч: - төрийн	4,039,977,493.00	4,603,894,247.92
51105	Нэмж төлөгдсөн капитал	277,420,366.00	00.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-	-
51210	Өмнөх үеийн үр дүн	1,134,465,800.12	1,281,419,961.19
51220	Тайлант үеийн үр дүн	-146,954,161.07	-284,259,394.92
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,079,029,228.27</u></b>	<b><u>3,098,793,373.76</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>757,928,518.94</b>	<b>637,202,877.01</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>293,251,689.94</b>	<b>267,678,959.01</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	293,251,689.94	267,678,959.01
120002	Хүүгийн орлого	3,039,824.07	678,685.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	279,816,830.87	268,488,957.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	279,816,830.87	268,488,957.82
120009	Бусад орлого	10,395,035.00	1,148,588.19
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	00.00	-2,637,272.73
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>464,676,829.00</b>	<b>369,523,918.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	464,676,829.00	369,523,918.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	464,676,829.00	369,523,918.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>904,882,680.02</b>	<b>921,462,271.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>904,882,680.02</b>	<b>921,462,271.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	904,882,680.02	921,462,271.93
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	904,882,680.02	921,462,271.93
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	892,389,382.61	915,185,029.93
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	164,416.41	201,900.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	12,328,881.00	6,075,342.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-146,954,161.08</u></b>	<b><u>-284,259,394.92</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-146,954,161.08</u></b>	<b><u>-284,259,394.92</u></b>

## 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>815,837,033.40</u></b>	<b><u>685,917,384.65</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>319,074,604.40</b>	<b>298,251,941.92</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	319,074,604.40	298,251,941.92
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	319,074,604.40	298,251,941.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	307,798,513.87	295,337,853.73
120009	Бусад орлого	11,276,090.53	2,914,088.19
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>496,762,429.00</b>	<b>387,665,442.73</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	496,762,429.00	387,665,442.73
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	496,762,429.00	387,665,442.73
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>723,237,786.50</u></b>	<b><u>688,599,382.27</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>723,237,786.50</b>	<b>688,599,382.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>723,237,786.50</b>	<b>688,599,382.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	362,676,632.00	371,802,793.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	362,676,632.00	371,802,793.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	77,449,720.85	87,748,973.59
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	77,449,720.85	87,748,973.59
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,873,783.00	57,209,122.24
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	34,873,783.00	57,209,122.24
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	165,780,285.00	93,333,562.60
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	19,498,832.00	23,740,180.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	146,281,453.00	69,593,382.60
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	82,457,365.65	78,504,930.84
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	64,979,763.00	70,391,770.84
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	17,477,602.65	8,113,160.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>92,599,246.90</u></b>	<b><u>-2,681,997.62</u></b>

	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>700,848.17</b>	<b>746,554.30</b>
140007	Хүлээн авсан хүүний орлого	700,848.17	746,554.30
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>34,550,000.00</b>	<b>140,300,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>34,550,000.00</b>	<b>140,300,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>34,550,000.00</b>	<b>140,300,000.00</b>
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	34,550,000.00	140,300,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-33,849,151.83</u></b>	<b><u>-139,553,445.70</u></b>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	30,211,372.69	2,744,928.89
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	30,211,372.69	2,744,928.89
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-211,372.69</u></b>	<b><u>-2,744,928.89</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>58,538,722.38</b>	<b>-144,980,372.21</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>87,959,721.59</b>	<b>146,498,443.97</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>146,498,443.97</b>	<b>1,518,071.76</b>

## 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,298,332,217.00	00.00	- 1,134,465,800.12	3,163,866,416.88
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>4,298,332,217.00</b>	<b>00.00</b>	- <b>1,134,465,800.12</b>	3,163,866,416.88
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-146,954,161.07	-146,954,161.07
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>4,317,397,859.00</b>	<b>00.00</b>	- <b>1,281,419,961.19</b>	3,035,977,897.81
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>4,317,397,859.00</b>	<b>00.00</b>	- <b>1,281,419,961.19</b>	3,035,977,897.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-277,420,366.00	00.00	00.00	-277,420,366.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>4,039,977,493.00</b>	<b>00.00</b>	- <b>1,281,419,961.19</b>	2,758,557,531.81
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	563,916,754.92	00.00	00.00	563,916,754.92
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-284,259,394.92	-284,259,394.92
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>4,603,894,247.92</b>	<b>00.00</b>	- <b>1,565,679,356.11</b>	3,038,214,891.81

## 4.5 Аудит хийсэн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>			1,141,771,900.00	1,140,117,055.81
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>			1,141,771,900.00	1,140,117,055.81
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>			1,141,771,900.00	1,140,117,055.81
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>			613,285,200.00	613,285,200.00
210101	Үндсэн цалин			420,479,700.00	420,479,700.00
210102	Нэмэгдэл			00.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			33,264,000.00	33,264,000.00
210104	Урамшуулал			00.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс			159,541,500.00	159,541,500.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>			88,525,900.00	87,007,010.00
210201	Тэтгэврийн даатгал			62,968,300.00	62,968,300.00
210202	Тэтгэмжийн даатгал			5,128,800.00	5,128,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал			6,382,800.00	6,382,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал			1,276,800.00	1,276,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал			12,769,200.00	11,250,310.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>			11,299,300.00	11,200,041.00
210301	Гэрэл, цахилгаан			984,500.00	899,256.00
210302	Түлш, халаалт			9,561,800.00	9,560,809.00
210303	Цэвэр, бохир ус			753,000.00	739,976.00
210304	Байрны түрээс			00.00	00.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>			198,340,300.00	198,340,299.50
210401	Бичиг хэрэг			1,050,800.00	1,232,448.00
210402	Тээвэр, шатахуун			30,561,500.00	30,284,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр			528,000.00	623,211.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			166,200,000.00	166,200,000.00
2105	<b>Нормативт зардал</b>			5,600,000.00	5,594,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			5,600,000.00	5,594,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>			62,512,900.00	62,512,862.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			3,000,000.00	2,999,980.00
210604	Урсгал засвар			59,512,900.00	59,512,882.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>			479,800.00	479,800.00
210702	Дотоод албан томилолт			479,800.00	479,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>			161,728,500.00	161,697,843.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			153,685,200.00	153,676,091.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ			6,289,000.00	6,288,983.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар			760,300.00	760,235.31
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			754,000.00	732,534.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>			1,141,771,900.00	1,141,771,900.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>			1,141,771,900.00	1,141,771,900.00
132001	Орон нутгийн төсвөөс			1,082,685,500.00	1,082,685,500.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>			66.00	65.00
620001	Удирдах ажилтан			01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан			08.00	08.00
620003	Үйлчлэх ажилтан			57.00	56.00
620004	Гэрээт ажилтан			00.00	00.00